Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.

Утас: 267497

Долоо хоног тутмын хэвлэл
2014 оны 06 дугаар сарын 23
№23 /836/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хууль

1035

Монгол Улсын хууль

1079

Соёлын өвийг хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай



Улаанбаатар хот
2014 он

Улсын Их Хурлын Тамгын газар

ГУРАВДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

11 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх

11.1.Монгол Улсын Ерөнхийлөгч соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.Их эзэн Чингис хаан, монголын хаад, хатдын булш, бунхан, дурсгалын орчин болон олдворыг судлах, хамгаалах, мэдээлэх ажлыг хэрэгжүүлэх талаар холбогдох этгээдэд чиглэл өгөх;

11.1.2.хууль бусаар алдагдсан соёлын өвийг Монгол Улсыг төлөөлөн гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нэхэмжлэх эрхийг итгэмжлэлээр олгох, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох;

11.1.3.Ерөнхийлөгчийн ивээл доор хамгаалж болох соёлын өвийг зарлах, уул, усыг төрийн тахилгатай болгох шийдвэр гаргах;

11.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

12.1.Улсын Их Хурал соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.соёлын өвийг хамгаалах, ашиглах талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

12.1.2.соёлын өвийг хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;

12.1.3.Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёлын өвийн дурсгалт газрыг улсын тусгай хамгаалалтад авах, түүний хилийн заагийг тогтоох;

12.1.4.соёлын өвийг хамгаалахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг батлах;

12.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

13 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

13.1.Засгийн газар соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.соёлын өвийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

13.1.2.соёлын өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх;

13.1.3.соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо, дүрмийг батлах;

13.1.4.язгуур гарал үүсэл нэг, илэрхийлэгдэх шинжээрээ нийтлэг, монгол угсаатны түүхэнд ач холбогдол бүхий соёлын өвийг хамгаалах талаар уг өв хадгалагдаж буй гадаад улстай хэлэлцээр хийх, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

13.1.5.улсын хилээр гарч алдагдсан соёлын биет өвийг эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

13.1.6.соёлын өвийн үзлэг, тооллого хийх, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг тус тус батлах;

13.1.7.улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

13.1.8.соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний болон түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг тус тус батлах;

13.1.9.Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

13.1.10.соёлын өвийг хувилан олшруулах, хуулбарлах, бүтээгдэхүүний загварт оруулах, кино, дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах, марк, ил захидал, цомог хийх журам батлах;

13.1.11.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам батлах;

13.1.12.түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох;

13.1.13.соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх болон Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэхтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган санхүжүүлэх;

13.1.14.хуульд заасан бусад бүрэн эрх.

14 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

14.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, зааврыг баталж, хэрэгжилтийг хангах;

14.1.2.соёлын өвийн улсын үзлэг, тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд явуулж, дүнг Засгийн газарт тайлагнах;

14.1.3.соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэгдсэн өвийг хадгалж хамгаалах арга хэмжээ авах;

14.1.4.соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журмыг тус тус батлах;

14.1.5.аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын саналыг харгалзан батлах;

14.1.6.түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлах;

14.1.7.соёлын өвийг хувилах, бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих;

14.1.8.дуудлага худалдаагаар худалдах соёлын биет өвийн бүртгэлийг хөтлөх, тайланг хүлээн авах, хяналт тавих;

14.1.9.нийтийн өмчийн соёлын өвийг хадгалах, бүртгэх ажлыг мэргэжлийн ажилтнаар гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

14.1.10.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

14.1.11.соёлын биет өвийг хилээр нэвтрүүлэх, сэргээн засварлах, палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл олгох;

14.1.12.соёлын өвийг судлах, сэргээн засварлах, зэрэглэл, үнэлгээ тогтоох чиг үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

14.1.13.соёлын өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэх журам батлах;

14.1.14.соёлын өвийн дурсгалт газрын менежментийн төлөвлөгөөг батлах;

14.1.15.соёлын өвийг хамгаалах, сурталчлах үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

14.1.16.соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны удирдлагыг томилж, чөлөөлөх;

14.1.17.хуульд заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

15.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал соёлын өвийг хамгаалах талаар дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.нутаг дэвсгэртээ соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, хяналт тавих;

15.1.2.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус хайгуул, малтлагаас урьдчилан сэргийлэх, соёлын өвийн зөрчлийн талаар олон нийтээс мэдээлэл авах, соёлын өвийг хамгаалах ажилд иргэдийг татан оролцуулах арга хэмжээ авах;

15.1.3.соёлын өвийг хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр Засаг даргад чиглэл өгч, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг хэлэлцэж дүгнэлт өгөх;

15.1.4.харьяалах нутаг дэвсгэр дэх түүх, соёлын дурсгалт газрыг хамгаалах чиглэлээр санал гаргах, хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих;

15.1.5.хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу орон нутгийн хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалт газрыг аялал жуулчлалын байгууллагад гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах;

15.1.6.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах арга хэмжээ авах;

15.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

15.2.Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталж, хилийн зааг, хамгаалалтын дэглэмийг тогтоон хяналт тавина.

16 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

16.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

16.1.2.соёлын өвийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, тухайн шатны иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

16.1.3.соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

16.1.4.соёлын өвийн судалгаа, тайлан мэдээллийг зохих журмын дагуу гаргаж, аймаг, нийслэл, улсын бүртгэл, мэдээллийн санд хүргүүлэх;

16.1.5.зохих журмын дагуу соёлын өвийн үзлэг, тооллого хийх;

16.1.6.соёлын өвд эрсдэл учруулахуйц аливаа үйл ажиллагааг таслан зогсоож, хуульд заасны дагуу арга хэмжээ авах;

16.1.7.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, багт дэмжлэг үзүүлэх;

16.1.8.соёлын өвийг сурталчлах;

16.1.9.дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

16.1.10.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, хуульд заасан дэмжлэг үзүүлэх;

16.1.11.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус малтлагыг таслан зогсоох, соёлын өвийн зөрчлийн талаарх мэдээллийн мөрөөр арга хэмжээ авах ажлыг удирдан зохион байгуулах;

16.1.12.соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах;

16.1.13.хуульд заасан бусад бүрэн эрх.

17 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

17.1.Сум, дүүргийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

17.1.2.соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

17.1.3.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага, багт зориулалт бүхий газрыг ашиглуулах;

17.1.4.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгааны ажил дуусаны дараа судалгаа явуулсан байгууллагаас уг газрыг аюул осолгүй болгохыг шаардах, хүлээн авах.

18 дугаар зүйл.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын бүрэн эрх

18.1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.соёлын өвийг хамгаалахад олон нийтийг татан оролцуулах;

18.1.2.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх саналыг дээд шатны хуралд хүргүүлэх;

18.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

19 дүгээр зүйл.Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

19.1.Баг, хорооны Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

19.1.2.палеонтологи, археологийн хууль бус хайгуул, малтлагыг таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх талаар холбогдох албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх;

19.1.3.түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний орчныг цэвэр үзэмжтэй байлгах, хог хаягдлыг цэвэрлэхэд иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;

19.1.4.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хуульд заасны дагуу урамшуулах, дэмжлэг үзүүлэх, дээд шатны байгууллагад уламжлах;

19.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ

20 дугаар зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо

20.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь дараах тогтолцоотой байна:

20.1.1.байгууллагын бүртгэл, мэдээллийн сан;
20.1.2.сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан;
20.1.3.аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан;
20.1.4.улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан.

20.2.Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санг соёлын төвд; аймгийн бүртгэл, мэдээллийн санг орон нутгийн музейд; нийслэлийн бүртгэл, мэдээллийн санг нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид; улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд тус тус бүрдүүлж, хадгална.

20.3.Соёлын өвийн үндэсний төв нь Монгол Улсын соёлын өвийг бүртгэх, мэдээлэх, авран хамгаалах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

20.4.Улс, орон нутгийн музей нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

20.5.Сум, дүүргийн соёлын төв нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах үүргийг гүйцэтгэнэ.

20.6.Дараах аж ахуйн нэгж, байгууллага бүртгэл, мэдээллийн санг заавал бүрдүүлнэ:

20.6.1.Монголбанк;
20.6.2.дурсгалт газрын хамгаалалтын захиргаа;
20.6.3.музей, галерей, номын сан, сүм хийд;
20.6.4.эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны лаборатори.

20.7.Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд иргэн, хуулийн этгээд өөрийн өмчилж, эзэмшиж байгаа соёлын өвийг бүртгүүлж болно.

20.8.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд түүнд агуулагдах мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байна.

20.9.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь төрийн өмчид байна.

20.10.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн байрлал, нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг тухайн санг бүрдүүлсэн байгууллага хариуцна.

21 дүгээр зүйл.Соёлын өвийн бүртгэлийн бүрдэл

21.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь соёлын өвийг эвдэрч гэмтсэн, устсан, мартагдсан тохиолдолд тэдгээрийг сэргээхэд шаардагдах бүрэн мэдээллийг агуулсан байвал зохино.

21.2.Соёлын өвийн бүртгэл нь дараах дагалдах хэрэглэгдэхүүнээс бүрдэнэ:

21.2.1.соёлын өвийн тодорхойлолт;
21.2.2.судалгаа, шинжилгээний ажлын тайлан;
21.2.3.сэргээн засварласан ажлын тайлан;
21.2.4.үзлэг, тооллого хийхэд хөтөлсөн баримт;
21.2.5.дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт;
21.2.6.гэрэл зураг, түүнийг агуулсан хальс, зээрэнцэг;
21.2.7.дуу, дүрс агуулсан бүх төрлийн бичлэг;
21.2.8.хэв, хуулбар, дардас;
21.2.9.соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн талаарх мэдээлэл;
21.2.10.сэргээн засварлах ажлын хэмжилт, судалгаа, зураг төсөл;
21.2.11.бүртгэлд холбогдох бусад хэрэглэгдэхүүн.

21.3.Соёлын өвийн бүртгэл, түүнд дагалдах хэрэглэгдэхүүн нь лавлагаа, мэдээллийн хувьд нэгдмэл цогц байх нөхцөлийг бүрдүүлнэ.

21.4.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүртгэлийг хуульд зааснаас бусад үндэслэлээр дамжуулах, ашиглуулах, хувилах, үрэгдүүлэх болон стандартын бус орчинд хадгалахыг хориглоно.

21.5.Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийг архивын байгууллагад хадгалуулна.

22 дугаар зүйл.Соёлын өвийг бүртгэх

22.1.Соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх, мэдээллийг ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх журмыг Монголбанкны Ерөнхийлөгч, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

22.2.Нийтийн өмчийн соёлын биет өвийн талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгэнэ.

22.3.Энэ хуулийн 22.2-т зааснаас бусад соёлын биет өвийг өмчлөгч, эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн зохих шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлж болно. Бүртгүүлсэн мэдээллийн нууцлал, хадгалалтын нөхцөлийг гэрээгээр зохицуулна.

22.4.Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тухай мэдээллийг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэнэ.

22.5.Соёлын өв устсан, үрэгдсэн тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр төрийн болон орон нутгийн өмчөөс хасна.

22.6.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангаас мэдээлэл хасахыг хориглоно.

23 дугаар зүйл.Соёлын өвийг бүртгэх хугацаа

23.1.Соёлын өвийг нээж, илрүүлсэн байгууллага, иргэн тухайн нутаг дэвсгэрийн бүртгэл, мэдээллийн санд 15 хоногийн дотор мэдэгдэж, анхан шатны бүртгэл хийлгэнэ.

23.2.Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан нь жилд дөрвөн удаа сум, дүүргийн, сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд хоёр удаа аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд нэг удаа улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тус тус тайлангаа хүргүүлнэ.

23.3.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон гадаадын байгууллага, иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын соёлын өвтэй холбоотой зүйлийг өөрийн санаачилгаар төрийн өмчид өгсөн тохиолдолд уг дурсгалыг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, түүнийг хадгалах үүрэг бүхий байгууллагад шилжүүлнэ.

24 дүгээр зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах

24.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр иргэн, хуулийн этгээдэд ашиглуулж болно. Мэдээллийг ашиглуулахдаа өмчлөгч, эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хөндөж үл болно.

24.2.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн мэдээллээр нийтэд зориулан сурталчилгааны хялбаршуулсан бүтээл гаргаж болно.

24.3.Соёлын биет өв алдагдсан тохиолдолд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хариуцсан байгууллага холбогдох мэдээллийг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагад нэн даруй хүргүүлэх арга хэмжээ авна.

25 дугаар зүйл.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын кадастр, өмчлөх, эзэмших эрхийн бүртгэл

25.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний оршин байгаа газрыг өмчлөгч, эзэмшигч нь эд хөрөнгийн эрхийн болон газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлнэ.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан бүртгэлийг Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд хадгална.

26 дугаар зүйл.Соёлын өвийн үзлэг, тооллого

26.1.Соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг таван жил тутамд, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна.

26.2.Соёлын өвийг эзэмшигч нь тооллогоор илэрсэн зөрчлийг арилгах талаар тухайн шатны нутгийн захиргааны байгууллага болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нэн даруй арга хэмжээ авна.

ТАВДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙН СУДАЛГАА

27 дугаар зүйл.Соёлын өвийн судалгаа

27.1.Соёлын биет өвийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ.

27.2.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байна.

27.3.Палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага хийх болон Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гадаадын иргэн, судалгааны баг, байгууллагад угсаатны судалгаа хийх зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

27.4.Соёлын өвийн судалгаа хийх журмыг соёлын болон шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

27.5.Эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад олгоно.

27.6.Авран хамгаалах хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн судлаачдын багт олгож болно.

27.7.Соёлын биет өвийг таньж тогтоох судалгаа, шинжилгээг өмчийн бүх хэлбэрийн эрдэм шинжилгээний лабораторид хийж болно.

27.8.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна.

27.9.Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна.

27.10.Урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.

27.11.Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх ажлыг холбогдох журмын дагуу мэргэжлийн соёл, урлаг, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд эрхлэн явуулна.

28 дугаар зүйл.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхэд хориглох зүйл

28.1.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхэд дараах зүйлийг хориглоно:

28.1.1.геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, усны эх, рашаан, булаг, бүрд зэрэг байгалийн унаган тогтоц, эмзэг хэсгийг гэмтээх;

28.1.2.тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх;

28.1.3.судалгааны үр дүнд хохирол учруулж болзошгүй техник, тоног төхөөрөмж ашиглах;

28.1.4.малтлага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээх.

29 дүгээр зүйл.Соёлын өвийн судалгааны ажлын тайлан

29.1.Соёлын өвийн судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлангийн нэг хувийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлнэ.

29.2.Тайлан бүрэн эхээрээ нийтлэгдээгүй тохиолдолд түүнийг ашиглах асуудлыг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн[4] дагуу шийдвэрлэнэ.

30 дугаар зүйл.Олдвор

30.1.Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр, газрын хэвлий нь төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа олдвор нь төрийн өмч мөн.

30.2.Олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний анхны төрх байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээхийг хориглоно.

[4]Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2006 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

30.3.Олдворыг стандартын шаардлага хангаагүй өрөө тасалгаа, орчинд хадгалахыг хориглоно.

30.4.Олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

30.5.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олдворыг хадгалах, эзэмших байгууллагад шилжүүлэхдээ илрүүлсэн эрдэм шинжилгээний байгууллагын саналыг харгалзана.

30.6.Олдворыг хадгалж, ашиглахдаа гарал үүслийн нэгдмэл цогц байдлыг хангана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙГ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨМЧЛӨХ

31 дүгээр зүйл.Соёлын биет өвийг эзэмших

31.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн байгууллага өмчлөгчийн тогтоосон нөхцөлөөр тус тус эзэмшинэ.

31.2.Доор дурдсан байгууллага, хуулийн этгээд нийтийн өмчийн соёлын биет өвийг эзэмшинэ:

31.2.1.улсын болон орон нутгийн музей;
31.2.2.галерей;
31.2.3.эрдэм шинжилгээний байгууллага;
31.2.4.үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн номын сан;
31.2.5.үндэсний төв архив, аймаг, нийслэлийн архив;
31.2.6.шашны байгууллага;
31.2.7.хууль тогтоомжоор соёлын өвийг хадгалж, хамгаалах үүрэг хүлээлгэсэн бусад байгууллага.

32 дугаар зүйл.Төрийн өмчийн соёлын биет өвийг эзэмшигчийн эрх, үүрэг

32.1.Соёлын биет өвийг эзэмшигч дараах эрх эдэлнэ:

32.1.1.өмчлөгчтэй тохиролцсоны дагуу нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд оролцуулах, түүнээс олсон орлогын тодорхой хувийг авах;

32.1.2.ангилал, зэрэглэлийг харгалзан холбогдох журмын дагуу тэдгээрийг түр солилцох, түрээслэх, худалдаж авах;

32.1.3.сурвалжлан олж цуглуулах, судалж шинжлэх, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах;

32.1.4.стандартын шаардлага хангасан байр, лаборатори, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдах;

32.1.5.соёлын биет өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлүүлэх.

32.2.Соёлын биет өвийг эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

32.2.1.соёлын өвийн бүртгэл хөтөлж, бүртгэл, мэдээллийн сан үүсгэх;

32.2.2.дээд шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

32.2.3.бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг бүртгэх;

32.2.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;

32.2.5.соёлын биет өв алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тухайн шатны бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

32.2.6.өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр соёлын биет өвийг сэргээн засварлах, бусдад ашиглуулахгүй байх.

33 дугаар зүйл.Соёлын биет өвийг өмчлөгчийн эрх, үүрэг

33.1.Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах эрх эдэлнэ:

33.1.1.язгуур зориулалтаар ашиглах;

33.1.2.нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд тавих, түүнээс олсон орлогоос авах;

33.1.3.зайлшгүй сэргээн засварлах шаардлагатай тохиолдолд зохих журмын дагуу улсаас санхүүгийн дэмжлэг авах;

33.1.4.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг өөрийн хүсэлтээр төрд худалдсан тохиолдолд татварын хөнгөлөлт эдлэх;

33.1.5.музей, галерей байгуулах.

33.2.Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

33.2.1.соёлын өвийн гарал үүслийн байдлыг тодорхойлох;

33.2.2.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

33.2.3.худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд мэдэгдэх;

33.2.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;

33.2.5.алдагдаж, үрэгдсэн тохиолдолд нэн даруй тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

33.2.6.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавих;

33.2.7.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд бэлэглэх, өвлүүлэх зэргээр түүний өмчлөлд шилжүүлэхгүй байх.

34 дүгээр зүйл.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн эрх, үүрэг

34.1.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нь дараах эрх эдэлнэ:

34.1.1.соёлын биет бус өвийг яаралтай хамгаалах, өвлүүлэх, сэргээн уламжлуулах зайлшгүй тохиолдолд санхүүгийн дэмжлэг авах.

34.2.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нь дараах үүрэг хүлээнэ:

34.2.1.соёлын биет бус өвийг хойч үедээ өвлүүлэх, шавь сургах;

34.2.2.соёлын биет бус өвийг сурталчилж, түгээн дэлгэрүүлэх;

34.2.3.соёлын биет бус өвийн бүртгэл хийх, мэдээлэл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

35 дугаар зүйл.Соёлын биет өвийг худалдах, худалдан авах

35.1.Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35.2.Соёлын биет өвийг худалдан авах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улс, орон нутгийн музей, номын сан олон нийтэд нээлттэй, ил тод хэлбэрээр зохион байгуулна.

35.3.Соёлын биет өвийг худалдан авсан байгууллага жил бүр үзэсгэлэн зохион байгуулж, нийтэд сурталчилна.

35.4.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд худалдахыг хориглоно.

35.5.Палеонтологи, археологийн олдворыг худалдахыг хориглоно.

36 дугаар зүйл.Соёлын биет өвийг ашиглах

36.1.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана.

36.2.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.

36.3.Төрийн өмчид байгаа соёлын биет өвийг язгуур зориулалтаар ашиглахыг хориглоно. Энэ хэсгийн заалт нь түүх, соёлын дурсгалт барилга, байшинд хамаарахгүй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО

37 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тогтолцоо

37.1.Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, эрх бүхий этгээд хариуцна.

37.2.Соёлын өвийн хамгаалалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавина.

37.3.Соёлын өвийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулахгүйгээр тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална. Хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр улс, орон нутгийн музейд шилжүүлэн хадгалж болно.

37.4.Сум, дүүргийн Засаг дарга түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үүргийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

37.5.Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд тухайн дурсгалын талаарх мэдээллийг агуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна. Танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийж, байрлуулах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

38 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа

38.1.Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно:

38.1.1.түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулах;

38.1.2.палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох;

38.1.3.хуульд зааснаас бусад тохиолдолд нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллага, орчинд шилжүүлэн хадгалах, зөөж тээвэрлэх, хөдөлгөх;

38.1.4.улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтээцийг өөрчлөх.

38.2.Палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгааны ажлын дүгнэлтээр соёлын өвд эрсдэл учирч болзошгүй байгаа нь тогтоогдсон бол аж ахуйн үйл ажиллагааг зогсоох үндэслэл болно.

38.3.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

39 дүгээр зүйл.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах

39.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бүх шатны Засаг дарга соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг тухайн угсаатан ястны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь уялдаатайгаар судалж, сурталчлах, өвлөн уламжлуулах, хадгалж хамгаалах асуудлыг хариуцна.

39.2.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлэх зорилгоор гурван жил тутам улсын хэмжээнд соёлын биет бус өвийн их наадмыг зохион байгуулна.

39.3.Соёлын биет бус өвийг хамгаалах, биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулах, шавь сургалт зохион байгуулах асуудлыг бүх шатны Засаг дарга зохион байгуулна.

40 дүгээр зүйл.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах

40.1.Соёлын өвийг сурвалжлан олсон, нээлт хийсэн, соёлын өвийн сан хөмрөгийг баяжуулах, авран хамгаалах, түүнийг олон нийтэд сурталчлан таниулах, сэргээн уламжлуулах, сэргээн засварлахад идэвх санаачилгатай ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна.

40.2.Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэнийг төрөөс алдаршуулж, урамшуулна.

40.3.Энэ хуульд заасан шаардлагыг зөрчсөн этгээдийг илрүүлсэн, соёлын өвийг хуулбарласан, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан тухай мэдээлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын байцаагч, гэрээт харуулд борлуулалтын орлогын 15 хувийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга олгоно.

40.4.Зөрчлийн тухай мэдээллийг худалдан авах журмыг Засгийн газар батална. Мэдээллийн нууцлалыг хууль тогтоомжийн дагуу чандлан хадгална.

40.5.Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчийг жил бүр тодруулж, мөнгөн шагнал олгох бөгөөд мөнгөн шагнал олгох журмыг Засгийн газар батална.

41 дүгээр зүйл.Соёлын өвийн санхүүжилт

41.1.Соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг доор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

41.1.1.улсын төсөв;
41.1.2.орон нутгийн төсөв;
41.1.3.Монгол Улсын болон гадаадын иргэн, олон улсын байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж;

41.1.4.бусад эх үүсвэр.

НАЙМДУГААР БҮЛЭГ
ДУРСГАЛТ ГАЗРЫГ ХАМГААЛАХ

42 дугаар зүйл.Соёлын өвийн дурсгалт газар

42.1.Улсын Их Хурал соёлын өвийн дурсгалт газрын унаган төрх, соёлын үнэт зүйлийн язгуур шинжийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргаж, хилийн заагийг батална.

42.2.Соёлын өвийн дурсгалт газар байгуулах саналыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт өргөн мэдүүлнэ. Саналд тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг харгалзан үзэж болно.

42.3.Соёлын өвийн дурсгалт газарт үндэсний болон дэлхийн өвийн дурсгалт газар хамаарна.

42.4.Соёлын өвийн дурсгалт газрыг дараах бүсэд хуваана:

42.4.1.хамгаалалтын бүс;
42.4.2.орчны бүс.

42.5.Соёлын өвийн дурсгалт газарт хэд хэдэн түүх, соёлын дурсгалт газар байрлаж болно.

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлтэй холбоотой зарим хуулийн заалтууд

★ ★ ★

"Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно".

/Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3/

☆ ☆ ☆

"Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй".

/Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3/

☆ ☆ ☆

"Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ".

/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 10/

☆ ☆ ☆

"Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ".

/Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 4/

★ ★ ★

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

244.	Соёлын өвийг хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/	1035
245.	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	1070
246.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1070
247.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1071
248.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1072
249.	Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1073
250.	Иргэний хуульд нэмэлт оруулах тухай	1074
251.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1075
252.	Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1075
253.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1076
254.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1077
255.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1077
256.	Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1078
257.	Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1078

42.6.Хамгаалалтын болон орчны бүсэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр байгаль, соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж болно.

42.7.Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын менежментийг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий хамгаалалтын захиргаа ажиллана.

42.8.Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа энэ хуулийн 43, 44-т заасан үйл ажиллагаатай уялдуулан нэмэлт дэглэм тогтоож болно.

42.9.Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаанд хэд хэдэн дурсгалт газрын хамгаалалтын асуудлыг харьяалуулж болно.

43 дугаар зүйл.Хамгаалалтын бүсийн дэглэм

43.1.Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

43.1.1.онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд нисэх онгоц буулгах;

43.1.2.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;
43.1.3.мод, элс, хайрга, чулуу авах зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;

43.1.4.хот суурин, цахилгаан станц байгуулах;
43.1.5.тэсэлгээ хийх;
43.1.6.шинээр барилга байгууламж барих.

44 дүгээр зүйл.Орчны бүсийн дэглэм

44.1.Орчны бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

44.1.1.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;
44.1.2.хот суурин, цахилгаан станц байгуулах;
44.1.3.тэсэлгээ хийх.

45 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт газар

45.1.Засгийн газар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, харагдах сүр бараг хадгалах зорилгоор хамгаалалтын бүс тогтооно.

45.2.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 45.1-д заасны дагуу хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилж ажиллуулна.

45.3.Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

45.3.1.газар, түүний хэвлийг хөндөх;
45.3.2.мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй мод бут, төрөл бүрийн ургамал тарих;

45.3.3.гэр, сууц, барилга, байгууламж барих;
45.3.4.мал бэлчээх;
45.3.5.онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд өөрөө явагч хэрэгсэл нэвтрүүлэх, нисэх онгоц буулгах;

45.3.6.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;
45.3.7.мод, элс, хайрга, чулуу авах.

45.4.Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд судалгаа шинжилгээ хийх, сэргээн засварлах, аялал жуулчлалын зорилгоор сурталчлах үйл ажиллагаа явуулж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ

46 дугаар зүйл.Соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллага

46.1.Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулсан сэргээн засварлах зураг төслийн дагуу соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага, иргэн гэрээгээр гүйцэтгэнэ.

46.2.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл ажиллана. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

46.3.Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

46.4.Хуульд өөрөөр заагаагүй бол соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага соёлын биет өвийг сэргээн засварлаж болно.

46.5.Соёлын биет өвийг зөвшөөрөлгүй сэргээн засварлахыг хориглоно.

46.6.Монгол Улсын хэмжээнд соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Соёлын биет өвийг сэргээн засварлах газар гүйцэтгэнэ.

46.7.Соёлын биет өвийг сэргээн засварлах ажилд туслан гүйцэтгэгчийг гэрээгээр ажиллуулж болно.

47 дугаар зүйл.Соёлын биет өвийг сэргээн засварлах үйл ажиллагаа

47.1.Соёлын биет өвийг сэргээн засварлахад дараах зарчмыг баримтална:

47.1.1.анхны төрх, хийц бүтээцийг хадгалж үлдээх;
47.1.2.аюулгүй, удаан хугацаанд хадгалах нөхцөлийг хангах.

47.2.Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

47.3.Соёлын биет өвийг сэргээн засварласан ажлын дэлгэрэнгүй тайланг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан, архивт шилжүүлнэ.

48 дугаар зүйл.Соёлын биет бус өвийг сэргээн уламжлуулах

48.1.Соёлын биет бус өв устсан, мартагдсан тохиолдолд сэргээн уламжлуулах арга хэмжээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох бүртгэл, мэдээллийг үндэслэн зохион байгуулна.

48.2.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөл соёлын биет бус өвийг сэргээгдсэнд тооцож, дүгнэлт гаргана.

АРАВДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙГ СУРТАЛЧЛАХ

49 дүгээр зүйл.Соёлын өвийн боловсрол

49.1.Соёлын өвийн талаарх мэдлэг олгох, түүнийг хамгаалах, сурталчлах арга хэмжээг гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлал болон боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

49.2.Соёлын өвийн боловсрол эзэмшүүлэх ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

49.2.1.соёлын өв, түүнийг хамгаалах мэдлэгийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн боловсролын сургалтын стандартад тусгах;

49.2.2.коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагын суралцагчид соёлын өвийг хамгаалах, ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй боловсрол эзэмшүүлэх;

49.2.3.олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр соёлын өвийг хамгаалах, өв уламжлал, ёс заншил, хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

50 дугаар зүйл.Соёлын өвийн үзэсгэлэн

50.1.Нийтийн өмчийн соёлын биет өвөөр дотоод, гадаадад үзэсгэлэн гаргах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнээс эрх олгосон байгууллага зохион байгуулна.

50.2.Энэ хуулийн 50.1-д заасан эрх бүхий байгууллага соёлын биет өвийг эзэмшигчтэй гэрээ байгуулна. Гэрээнд биет өвийг ашиглах нөхцөл, хугацаа, даатгалын баталгааны хэмжээ, түрээсийн төлбөр, ашиглагч этгээдийн хүлээх хариуцлага, хамгаалалтын болон эрсдэлийн баталгааны нөхцөлийг тусгана.

50.3.Хувийн өмчийн соёлын өвийг өмчлөгч, эзэмшигчтэй нь байгуулсан гэрээний үндсэн дээр үзэсгэлэнд оролцуулж болно.

50.4.Соёлын биет өвийг гадаадад үзэсгэлэнд гаргах гэрээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянана.

50.5.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй палеонтологи, археологийн олдвор, дурсгалаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн гаргах, музей байгуулахыг хориглоно.

51 дүгээр зүйл.Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх

51.1.Соёлын биет өвийг хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг бүрэн хангасны үндсэн дээр зөөж тээвэрлэнэ.

51.2.Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журмыг Засгийн газар тогтооно.

52 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх

52.1.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл, эх олдворыг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Засгийн газрын зөвшөөрлөөр нэг жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлнэ. Энэ хэсгийн заалт нь түүний хувилсан эх хуулбарт хамаарахгүй.

52.2.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг соёлын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

52.3.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 52.1-д зааснаас бусад түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг дараах зорилгоор, эргүүлэн авчрах нөхцөлтэйгээр улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно:

52.3.1.палеонтологи, археологийн олдворыг судалж шинжлүүлэх;

52.3.2.сэргээн засварлах;

52.3.3.гадаад улсад үзэсгэлэнд гаргах;

52.3.4.өмчлөгч өөрөө язгуур зориулалтаар нь ашиглах.

52.4.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр хоёр жилээс дээшгүй хугацаагаар нэвтрүүлнэ. Энэ хуулийн 52.3.1, 52.3.2-т заасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд уг хугацааг сунгаж болно.

52.5.Энэ хуулийн 52.3-т заасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлж байгаа этгээд түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангасан байна.

52.6.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу мэдээллийг үйлдэж, хадгалалтын

байдлын тайлан, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулан соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулна.

52.7.Хууль бусаар гадаадад гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, эсхүл энэ хуулийн 52.1, 52.3-т заасны дагуу улсын хилээр гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тэдгээрийг Монгол Улсын өмч болохыг зарлах бөгөөд эргүүлж авчрах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон цагдаагийн байгууллага хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулна.

52.8.Шүүхийн шийдвэрээр төрийн өмчид шилжүүлсэн болон гаалийн байгууллагад хураагдсан соёлын биет өвийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрөл зүйлээр нь ялгаж, холбогдох журмын дагуу мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.

53 дугаар зүйл.Соёлын өвийг хувилах

53.1.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөлгүйгээр нийтийн өмчийн соёлын биет өвийг 1:1 масштабаар хувилан олшруулахыг хориглоно.

53.2.Энэ хуулийн 53.1-д зааснаас өөр масштабаар хувилан олшруулах эрхийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

53.3.Соёлын өвийг хувилах болон бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

54 дүгээр зүйл.Соёлын өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх

54.1.Энэ хуулийн 53.2-т заасан зөвшөөрөл авсан этгээдтэй мерчандайзийн гэрээг зөвхөн улсын болон орон нутгийн музей, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон соёлын бусад байгууллага байгуулна.

54.2.Улс, орон нутгийн музей болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон соёлын бусад байгууллага нь бүтээгдэхүүний борлуулагч байж болно.

54.3.Улс, орон нутгийн музей болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагч нь мерчандайзийн гэрээ байгуулна. Гэрээний загварыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
МЕРЧАНДАЙЗИЙН ГЭРЭЭ

55 дугаар зүйл.Мерчандайзийн гэрээ

55.1.Иргэний хуулийн[5] 338[1] дүгээр зүйлийн дагуу мерчандайзийн гэрээгээр өмчлөгч, түүний зөвшөөрснөөр эзэмшигч нийтийн өмчийн соёлын өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь эзэмшигчид борлуулалтын орлогоос соёлын өвийн загвар ашигласны төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

55.2.Мерчандайз нь барааны тэмдэг, бүтээгдэхүүний загварын эрхээр хамгаалагдана.

56 дугаар зүйл.Мерчандайзийн гэрээний талууд

56.1.Дараах этгээд мерчандайзийн гэрээний тал байна:

56.1.1.нийтийн болон хувийн өмчийг өмчлөгч;

56.1.2.улс, орон нутгийн музей, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх олгосон соёлын бусад байгууллага;

56.1.3.эрх олгогдсон үйлдвэрлэгч, борлуулагч.

57 дугаар зүйл.Мерчандайзийн гэрээний нөхцөл

57.1.Хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол мерчандайзийн гэрээг Иргэний хуулийн дагуу бичгээр байгуулж дараах зүйлийг тусгана:

57.1.1.мерчандайзийн зүйлийн хэмжээ, загвар, өнгө, материалын дэлгэрэнгүй тодорхойлолт;

57.1.2.мерчандайзийн гэрээний дагуу үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний тоо хэмжээ;

57.1.3.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах борлуулагч, борлуулах цэгийн мэдээлэл;

[1] Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

57.1.4.мерчандайзийн зүйлийг үйлдвэрлэх, борлуулахад шаардлагатай санхүүжилтийн хэлбэр, нөхцөл;

57.1.5.мерчандайзийн зүйлийг гэрээнд заасны дагуу үйлдвэрлэх, борлуулах болон чанарын баталгаа;

57.1.6.соёлын өвийн загвар ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөл;

57.1.7.мерчандайзийн гэрээний хугацааг сунгах, гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, мерчандайзийн гэрээ ба холбогдох бусад гэрээ хоорондын харилцаа, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлэхгүй тохиолдол ба гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, маргаан шийдвэрлэх журам;

57.1.8.талууд харилцан тохиролцсон бусад зүйл.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙН ХЯНАЛТ

58 дугаар зүйл.Соёлын өвийн хяналт

58.1.Соёлын өвийн хяналтыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга, улсын байцаагч, гэрээт харуул хэрэгжүүлнэ.

58.2.Соёлын өвийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, дүрэм журам, түүнтэй холбогдсон норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

58.3.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтад байгаль орчны хяналтын улсын байцаагч хяналт тавина.

58.4.Соёлын өвийн хяналтын улсын байцаагчийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

58.5.Соёлын өвийн гэрээт харуулыг сум, дүүргийн Засаг дарга томилно.

59 дүгээр зүйл.Соёлын өвийн гэрээт харуулын эрх, үүрэг

59.1.Соёлын өвийн гэрээт харуул нь дараах эрх, үүрэгтэй:

59.1.1.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаарх мэдээлэл, хамгаалалтын хэрэгслээр хангагдах, цалин хөлс, урамшуулал авах;

59.1.2.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтлийг засварлах, авран хамгаалах талаар эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх;

59.1.3.түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг үзэж сонирхох, судлахаар ирсэн иргэнийг бүртгэх, тэдний багаж хэрэгслийг шалгах, соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг тайлбарлаж таниулах;

59.1.4.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын орчинд зөвшөөрөлгүйгээр металл хайгч, тусгай багаж ашиглуулахгүй байх;

59.1.5.хууль бус хайгуул, малтлага хийхийг хориглох, таслан зогсоох, үйл ажиллагааг нь баримтжуулах, мэдээлэх;

59.1.6.хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн этгээдийг улсын байцаагч болон холбогдох хуулийн байгууллагад мэдээлэх;

59.1.7.хамгаалж байгаа соёлын өвийн ойролцоо байнга оршин суух.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ

60 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

60.1.Соёлын өвийг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, соёлын болон байгаль орчны хяналтын улсын байцаагч, сум, дүүргийн Засаг дарга гэм буруутай этгээдэд дараах шийтгэл ногдуулна:

60.1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал болон мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй үүрэг бүхий этгээдийг 100000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500000 төгрөгөөр торгох;

60.1.2.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг хууль бусаар бусдад дамжуулсан, ашиглуулсан, хувилсан, үрэгдүүлсэн, хассан зөрчил гаргасан үүрэг бүхий этгээдийг 1000000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3000000 төгрөгөөр торгох;

60.1.3.соёлын өвийг хуульд заасан хугацаанд бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй бол зөрчлийг арилгуулж, иргэнийг 100000 төгрөгөөр, үүрэг бүхий этгээдийг 300000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500000 төгрөгөөр торгох;

60.1.4.соёлын өвийн судалгаа, шинжилгээ хийхдээ язгуур шинж, унаган төрх байдал, хүрээлэн байгаа орчны зохиомжийг эвдэж, хууль тогтоомжоор тогтоосон журам, стандартыг зөрчсөн бол учруулсан хохирлыг төлүүлж, үүрэг бүхий этгээдийг 500000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 2000000 төгрөгөөр торгох;

60.1.5.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдсан, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлсэн, зуучилсан бол уг дурсгалт зүйлийг хураан авч, улсын орлого болгон иргэнийг 5000000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 15000000 төгрөгөөр торгох;

60.1.6.соёлын биет өвийг сэргээн засварлах хуулиар тогтоосон журам, стандартыг зөрчсөн иргэнийг 500000 төгрөгөөр, үүрэг бүхий этгээдийг 2000000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 10000000 төгрөгөөр торгох;

60.1.7.соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хууль тогтоомжоор тогтоосон хориглолт, журам, стандарт зөрчсөн, анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирлыг төлүүлж, иргэнийг 500000 төгрөгөөр, үүрэг бүхий этгээдийг 1000000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 5000000 төгрөгөөр торгох;

60.1.8.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд байрлуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг эвдэж устгасан, дурсгал дээр ханын самбар, зурагт хуудас, түүнтэй адилтгах бусад хэрэгслийг байрлуулсан бол учруулсан хохирлыг төлүүлж, иргэнийг 100000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500000 төгрөгөөр торгох;

60.1.9.соёлын өвийн болон түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэм зөрчсөн иргэнийг 500000 төгрөгөөр, үүрэг бүхий этгээдийг 2000000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 10000000 төгрөгөөр торгох;

60.1.10.газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад илэрсэн соёлын биет өвийг хамгаалах, мэдээлэх арга хэмжээ аваагүй иргэнийг 5000000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 20000000 төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг цуцлах тухай саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

60.1.11.нийтийн өмчийн соёлын биет өвийг 1:1 масштабаар зөвшөөрөлгүй хувилан олшруулсан бол энэ үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж, иргэнийг 2000000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 10000000 төгрөгөөр торгох.

61 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

61.1.Энэ хуулийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс, мөн хуулийн 20.3, 20.4, 20.5, 46.6, 58.1 дэх хэсгийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2001 оны 06 дугаар сарын 08-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.7.10 дахь заалт нэмсүгэй:

"15.7.10.соёлын өвийг сэргээн засварлах, палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх."

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/40^{1}, 40^{2} дугаар зүйл:

"40^{1} дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах

40^{1}.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 40^{2}, 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.

40^{1}.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.

40^{2} дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

40^{2}.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь соёлын өвийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

40^{2}.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, улсын хяналтын байцаагчид хайгуулын талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх боломцоо олгох;

40^2.1.2.ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ."

2/56 дугаар зүйлийн 56.1.7 дахь заалт:

"56.1.7.хайгуулын талбайд соёлын өв байгаа нь тогтоогдсон."

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэг:

"31.4.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна."

2/34 дүгээр зүйлийн 34.11 дэх хэсэг:

"34.11.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газар эзэмших гэрээ байгуулахаас өмнө уг газарт палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна."

2 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"40.1.4.байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй, энэ хуулийн 31.4-т заасны дагуу палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгаа хийлгээгүй, зөвшөөрөл аваагүй нь тогтоогдсон;"

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Захиргааны хариуцлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай 30^7 дугаар зүйл нэмсүгэй:

"30^7 дугаар зүйл.Соёлын өвийн хяналтын байцаагч, гэрээт харуулын хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх

30^7.1.Соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуулын хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан, эсэргүүцсэн, албан үүргээ биелүүлэхэд нь санаатайгаар саад учруулсан, албан үүрэгтэй нь холбогдуулан тэдгээрийг доромжилсон, гүтгэсэн, заналхийлсэн, хүч хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг 100-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 1000-60000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэлийг шүүгч ногдуулна."

2 дугаар зүйл.Захиргааны хариуцлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь заалтын "30^3," гэсний дараа "30^7," гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуульд доор дурдсан агуулгатай 338^1 дүгээр зүйл нэмсүгэй:

"338^1 дүгээр зүйл.Мерчандайзийн гэрээ

338^1.1.Мерчандайзийн гэрээгээр бие хүний нэр, төрх, дуу хоолой болон утга зохиол, урлагийн бүтээл, эд зүйлийн дүр, зургийг бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах эрхийг өмчлөгч, эзэмшигчээс үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь өмчлөгч, эзэмшигчид борлуулалтын орлогоос нэр, төрх, дуу, хоолой, дүр, зургийг ашигласны төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

338^1.2.Хуульд өөрөөр заагаагүй бол мерчандайзийн гэрээг бичгээр хийнэ."

2 дугаар зүйл.Иргэний хуулийн Хорин есдүгээр бүлгийн гарчгийн "Франчайз" гэсний дараа ", Мерчандайз" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.1.23 дахь заалт:

"13.1.23.соёлын өвийг судалж шинжлэх, сэргээн засварлахад ашиглах техник, тоног төхөөрөмж, бодис, багаж хэрэгсэл, материал. Энэ жагсаалтыг Засгийн газар батална."

2/13 дугаар зүйлийн 13.6.15 дахь заалт:

"13.6.15.соёлын өвийг сэргээн засварлах үйлчилгээ."

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2.Сүм хийд өөрийн эзэмшилд болон өмчлөлд байгаа газраас үл салах түүх, соёлын үл хөдлөх дурсгал, бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд, дурсгалын талаарх мэдээллийг соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлнэ."

2 дугаар зүйл.Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газар."

2/24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Дэлхийн болон Үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын дэглэмийг хуулиар тогтооно."

2 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Газрын тухай хууль" гэсний дараа "Соёлын өвийг хамгаалах тухай хууль," гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Тусгай хамгаалалттай газар нутгийн" гэснийг "Хуульд өөрөөр заагаагүй бол Тусгай хамгаалалттай газар нутгийн" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

"22.1.13.соёлын өвийг сэргээн засварлах, палентологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл олгоход 300000-500000 төгрөг."

2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.12 дахь заалтын "түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл" гэснийг "соёлын өвийг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.17 дахь заалт нэмсүгэй:

"16.1.17.соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн хандив."

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх заалтын "иргэдэд үнэт металл," гэснийг "иргэдэд соёлын өвд хамаарахаас бусад үнэт металл," гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй:

"11.2.4.улсын болон орон нутгийн музей, үндэсний номын сан."

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах 16.1.6 дахь заалт нэмсүгэй:

"16.1.6.шинээр барилга байгууламж барих, өргөтгөх зорилгоор газар, түүний хэвлийг хөндөхөөс өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах, илэрсэн дурсгалыг авран хамгаалах."

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Авто замын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.7 дахь хэсэг нэмсүгэй:

"13.7.Шинээр авто зам, замын байгууламжийг барих зорилгоор газар, түүний хэвлийг хөндөхөөс өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах, илэрсэн дурсгалыг авран хамгаалах үүрэгтэй."

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр — Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Компанийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

258.	Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай		1078
259.	Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай		1079
260.	Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1079
261.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1082
262.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1083
263.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		1084
	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ		
264.	Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 40	1084
265.	Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	Дугаар 41	1085
266.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай	Дугаар 42	1085
	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ		
267.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 73	1086
268.	Зарим шүүгчдийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 74	1086
269.	Зарим шүүгчдийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 75	1087
	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		
270.	Мөнгөн шагнал олгох тухай	Дугаар 136	1088

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж

2.1.Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Соёлын тухай[2], Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль[3], энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."соёлын өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг;

3.1.2."соёлын биет өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг;

3.1.3."түүх, соёлын үл хөдлөх дурсгал" гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дурсгалыг;

[1]Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
[2]Соёлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1996 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[3]Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

1/6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсэг:

"6.13.Төр болон бусад хуулийн этгээд аливаа компанид хөрөнгө оруулсныхаа төлөө эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээ хэрэгжүүлэхдээ дүрэмдээ заасан эрх бүхий этгээдээс томилсон төлөөлөгчөөр дамжуулан төлөөллөө хэрэгжүүлэх бөгөөд энэхүү төлөөлөгч нь уг төлөөллийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль болон тухайн компанийн дүрэмд заасан эрх бүхий этгээдээс өгсөн удирдамжийг үндэслэх ба энэхүү удирдамжаас өөрөөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэслэл болно."

2/18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг:

"18.7.Санхүүгийн зохицуулах хороо хувьцаат компанийн өөрчлөн байгуулагдах, татан буулгах тухай шийдвэрийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрсөн бол уг бүртгэлийг улсын бүртгэлд бүртгүүлнэ."

3/57 дугаар зүйлийн 57.8 дахь хэсэг:

"57.8.Санхүүгийн зохицуулах хороо компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигч болохоо нотолсон мэдэгдлийг үндэслэн тухайн хяналтын багц эзэмшигчээс энэ хуулийн 57.1-д заасны дагуу санал гаргахыг шаардах үүрэгтэй."

4/58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэг:

"58.2.Энэ хуулийн 58.1-д заасан мэдэгдлийг компани болон Санхүүгийн зохицуулах хороо хүлээн авч өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ."

5/60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэг:

"60.5.Энэ хуулийн 60.2.8-д заасан хурлын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалах боломжгүй болсон тохиолдолд энэ тухайгаа төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-д мэдэгдэх ба төлөөлөн удирдах зөвлөл хурлын даргыг хурал болохоос өмнө дахин томилно."

6/79 дүгээр зүйлийн 79.1.5 дахь заалт:

"79.1.5.хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлага."

2 дугаар зүйл.Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.10, 62.1.11 дэх заалтын "энэ хуулийн" гэсний өмнө "төлөөлөн

удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд" гэж, 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсгийн "тус бүрээр" гэсний дараа "хурлын ирц болон" гэж, 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсгийн "хуралдах өдрийг" гэсний дараа "төлөөлөн удирдах зөвлөл" гэж, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн "хурал" гэсний өмнө "ээлжит" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Компанийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"57.1.Хувьцаат компанийн хувьцааг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авснаар тухайн этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь хяналтын багц болон түүнээс дээш хэмжээнд хүрсэн бол хяналтын багц эзэмшигч болсон өдрөөс хойш ажлын 60 өдрийн дотор бусад хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн зургаан сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал гаргах үүрэгтэй.

57.2. Энэ хуулийн 57.1-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь уг саналыг гаргаж зохих журмын дагуу хэрэгжүүлэх хүртэл хугацаанд энэ хуулийн 62.1.9-62.1.16-д заасан асуудлаар саналын эрхгүй байна."

4 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн "үүсгэн байгуулагчдын" гэснийг "байгуулах үеийн хувьцаа эзэмшигчдийн" гэж, 5.2 дахь хэсгийн "нийтэд санал болгон үнэт цаас гаргахгүй" гэснийг "бусад үнэт цаасыг нээлттэй болон хаалттай аль ч хэлбэрээр гаргаж болно" гэж, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийн "Хувьцаа эзэмшигчдийн" гэснийг "Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн" гэж, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн "тухайн хурал хуралдах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө байна" гэснийг "хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй" гэж, 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын "дүгнэлт гаргах" гэснийг "дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах" гэж, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсгийн "Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолно." гэсэн 1 дэх өгүүлбэрийг "Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох саналыг тус тусад тоолно." гэж, 79 дүгээр зүйлийн 79.1.2 дахь заалтын "эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй" гэснийг "ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй" гэж, мөн зүйлийн 79.2 дахь хэсгийн "дэвшүүлж" гэснийг "дэвшүүлэх саналаа тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хороонд ирүүлж"

гэж, 80 дугаар зүйлийн 80.13 дахь хэсгийн "хувьцаа эзэмшигчдийн" гэснийг "төлөөлөн удирдах зөвлөлийн" гэж, 99 дүгээр зүйлийн 99.1.2 дахь заалтын "энэ хуулийн 6.13-д" гэснийг "энэ хуулийн 6.14-т" гэж, 6 дугаар зүйлийн 6.13-6.15 дахь хэсгийн дугаарыг "6.14-6.16" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.10 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмсүгэй:

"3/энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газар тогтоох."

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "Төрийн өмчийн хороо" гэсний дараа "болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээд" гэж, мөн хэсгийн 3 дахь заалтын "албан хаагч" гэсний дараа "болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээдийн ажилтан" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1/төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг уг хуралаар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийн хамт төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд томилох;

2/төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд нэр дэвшүүлэх хороо тэрхүү нэр дэвшигдэж байгаа этгээд нь хуульд заасны дагуу төрийг төлөөлөх этгээд мөн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах үүрэгтэй;"

4 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн "Төрийн өмчийн хорооноос" гэснийг "болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс" гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хот

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн "Албан тушаалтан" гэснийг "Хуульд өөрөөр заагаагүй бол албан тушаалтан" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр — Улаанбаатар хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалт:

"20.1.9.хувьцаат компанийг шинээр болон өөрчлөн байгуулагдах хэлбэрээр байгуулж байгаа бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн шийдвэр."

2/25 дугаар зүйлийн 25.1.4 дэх заалт:

"25.1.4.хувьцаат компанийн хувьд түүний хувьцааг бүртгэлээс хассан тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА — **З.ЭНХБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 05 дугаар сарын 27-ны өдөр — Дугаар 40 — Улаанбаатар хот

Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар нараас 2013 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн

Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тухайн асуудлаар хууль гаргах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА — **З.ЭНХБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр — Дугаар 41 — Улаанбаатар хот

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан компанид төрийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг энэ хуульд нийцүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т, Санхүүгийн зохицуулах хорооноос өмнө баталсан холбогдох журам, зааварт зохих өөрчлөлт оруулахыг Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

2.Энэ тогтоолыг 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА — **З.ЭНХБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 06 дугаар сарын 12-ны өдөр — Дугаар 42 — Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн

3.1.4."түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл" гэж тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг;

3.1.5."соёлын биет бус өв" гэж хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг;

3.1.6."соёлын өвийн дурсгалт газар" гэж соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн соёлын орон зай, газар нутгийг;

3.1.7."түүх, соёлын дурсгалт газар" гэж энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүхий газар, түүний хэвлийг;

3.1.8."соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч" гэж соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн, түүнийгээ олны хүртээл болгож, дараагийн үедээ өвлүүлэн уламжлуулж байгаа хамт олон, бүлэг, хувь хүнийг;

3.1.9."шавь сургалт" гэж соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаас тодорхой мэдлэг, арга ухаан, ур чадварыг шавьдаа биечлэн заан сургаж, эзэмшүүлдэг сургалтын арга барилыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН ӨВИЙН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

4 дүгээр зүйл.Соёлын өвийн ангилал

4.1.Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна.

4.2.Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.

4.3.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь дангаар болон цогцолбор байдлаар оршино.

5 дугаар зүйл.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал

5.1.Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:

5.1.1.эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;

5.1.2.эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;

5.1.3.чулуун зэвсгийн олдворт газар;

5.1.4.хадны зураг, бичээс;

5.1.5.булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;

5.1.6.эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;

5.1.7.хөшөө дурсгал;

5.1.8.эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;

5.1.9.тахилгат газар;

5.1.10.түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;

5.1.11.бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

6 дугаар зүйл.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл

6.1.Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамааруулна:

6.1.1.ховор эрдэс;

6.1.2.эрдэнийн чулууны ховор олдвор;

6.1.3.солир;

6.1.4.ховор болон ховордсон ургамлын хатаамал цуглуулга, амьтны чихмэл;

6.1.5.эртний ургамал, амьтны олдвор;

6.1.6.археологийн олдвор;

6.1.7.угсаатны хувцас, чимэглэл;

6.1.8.уламжлалт аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг;

6.1.9.угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл;

6.1.10.уламжлалт тоглоом, наадгай;

6.1.11.уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл;

6.1.12.бичгийн дурсгалт зүйл;

6.1.13.дүрс, дуу авианы баримт;

6.1.14.дүрслэх урлагийн бүх төрлийн бүтээл, холбогдох эд өлгийн зүйл;

6.1.15.уламжлалт монгол эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэрэглэгдэхүүн, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;

6.1.16.гэр, сууц, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;
6.1.17.бусад түүх, соёлын дурсгалт зүйл.

6.2.Энэ хуулийн 5.1.1, 6.1.1-6.1.3-т зааснаас бусад байгалийн өвийг хамгаалах асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

7 дугаар зүйл.Соёлын биет бус өв

7.1.Дараах соёлын өвийг соёлын биет бус өвд хамааруулна:

7.1.1.эх хэл, бичиг, түүний хүрээний соёл;
7.1.2.аман зохиолын уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэр;
7.1.3.урлагийн тоглох үзүүлбэр;
7.1.4.үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил;

7.1.5.уламжлалт гар урлалын дэг сургууль, арга барил;
7.1.6.ардын ёс заншил, зан үйл;
7.1.7.ардын уламжлалт мэдлэг, арга ухаан;
7.1.8.ардын бэлгэдэх ёсны уламжлал;
7.1.9.үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйл;

7.1.10.ардын уламжлалт технологи;
7.1.11.угийн бичиг хөтлөх уламжлал;
7.1.12.гэрийн дэг сургуулийн шилдэг өв уламжлал;
7.1.13.уламжлалт шашин, шүтлэгийн зан үйл, ёс заншил;
7.1.14.газар, усны уламжлалт нэр;
7.1.15.бусад соёлын биет бус өв.

8 дугаар зүйл.Соёлын өвийн зэрэглэл

8.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалтын түвшингээр нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалттай гэж зэрэглэнэ.

8.2.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээс энэ хуулийн 8.3-т заасан шалгуурын дагуу хосгүй үнэт, үнэт гэж зэрэглэл тогтооно.

8.3.Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлийг дараах шалгуураар тогтооно:

8.3.1.түүх, соёл, урлаг, гоо зүй, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол;

8.3.2.холбогдох цаг үе;
8.3.3.дахин давтагдашгүй байдал;
8.3.4.ур хийц, дэг сургууль;
8.3.5.үнэт металлын орц, эрдэнийн чулууны хэмжээ.

8.4.Соёлын биет бус өвийг төлөөллийн үндэсний жагсаалт болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад бүртгэж хамгаална.

8.5.Энэ хуулийн 8.4-т заасан жагсаалтад оруулах соёлын биет бус өвийг дараах шалгуураар тогтооно:

8.5.1.түүх, соёл, заншил, уламжлалыг илэрхийлэх байдал;
8.5.2.ховордсон, устсан, эрсдэлд орсон байдал.

9 дүгээр зүйл.Соёлын өвийн үнэлгээ

9.1.Соёлын биет өвийн үнэлгээ хийх журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

9.2.Нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөл тодорхойлно.

9.3.Хувийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээг өмчлөгчийн хүсэлтээр энэ хуулийн 9.2-т заасны дагуу тодорхойлж болно.

10 дугаар зүйл.Соёлын биет өвийн даатгал

10.1.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үзэсгэлэнд оролцуулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээ хийлгэх зорилгоор Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд заавал даатгуулна.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаас бусад тохиолдолд соёлын биет өвийг даатгуулж болно.